

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.06.24 № 03/5465

танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ТБ/20240101003/02/02 дугаартай “Баян-Өлгий аймаг - Цэнгэл тооцооны төвийн барилга угсралтын ажил”-ын тендер шалгаруулалтад оролцсон “Еба констракшн” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Еба констракшн” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Өлке констракшн” ХХК-ийн тендерт санал болгосон ХАБЭА-н хариуцсан ажилтны гэрчилгээ холбогдох сургалтад хамрагдсан эсэх нотлогдохгүй ба хуурамч байж болзошгүй, авто краны даац 5 тн даацтай бус, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт ирүүлсэн буюу холбогдох үүрэг даалгаврын биелэлтийн хуудсыг ирүүлээгүй, ажил гүйцэтгэх хугацааны нарийвчилсан хуваарьт хүн, цагийг тодорхойлоогүй нь шаардлага хангахгүй байх тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсан үндэслэлээр “Өлке констракшн” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан - 1 байх, ХАБЭА-н сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байх. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан тухай гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. Бусад албан тушаалтай хавсарсан байж болно.” гэж заасан байна.

“Өлке констракшн” ХХК тендерт ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтанд Асгутын Ахмаралыг санал болгож, түүнд Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвөөс 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр олгосон 21/34-403 дугаартай Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны сертификатыг нотариатаар гэрчлүүлж хавсаргаж ирүүлснийг дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Гомдолд дурдсан www.new.tender.gov.mn хаяг нь хуульд заасан худалдан авах ажиллагааны цахим системийн үндсэн домэйн нэр биш, тус хаяг дээр ХАБЭА-н асуудал хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтны сургалтад

хамрагдсан төгсөгчдийн бүртгэл хийгддэггүй, түүнчлэн тус хаягт “Өлке констракшн” ХХК-ийн тендер санал болгосон ХАБЭА-н хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй асуудал хариуцсан ажилтны мэдээлэл “хайлтын үр дүн илэрсэнгүй” гэх мэдээлэлтэй байгааг үндэслэн тухайн гэрчилгээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй болохыг анхаарах нь зүйтэй байна.

2.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ижил төстэй гэрээний туршлага: 2022, 2023 онуудын гэрээний үнийн дүнгийн нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй барилга угсралтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажиллаж хүлээлгэн өгсөн байна. Гэрээний хуулбар ирүүлнэ. Гэрээний үүргээ биелүүлсэн тухай захиалагчийн тодорхойлолт эсхүл гэрээ дүгнэсэн акт /ажил хүлээлцсэн акт/-ыг ирүүлнэ.” гэж, ТШЗ 2.1-д “Нийт төсөвт өртөг: 494,647,843 (Дөрвөн зуун ерэн дөрвөн сая зургаан зуун дөчин долоон мянга найман зуун дөчин гурван) төгрөг” гэж тус тус заасан байна.

Ижил төстэй гэрээний туршлагад “Өлке констракшн” ХХК-ийн ирүүлсэн гэрээний мэдээллээс төсөвт өртгөөс багагүй үнийн дүнтэй бөгөөд 2022, 2023 онд хамаарах гэрээ нь Боловсрол, шинжлэх ухааны яамтай байгуулсан 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр үргэлжилсэн БШУЯ/202001295 дугаартай “Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Цэнгэл сум/-ын барилга угсралтын ажил”-ын гэрээ /гэрээний үнэ: 1,600,206,251.0 төгрөг/, Боловсролын ерөнхий газартай байгуулсан 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан БШУЯ/202212143 дугаартай “Сургуулийн дотуур байрны шинэчлэл, тохижилт /Увс, Ховд сум/-ын ажил”-ын гэрээ /гэрээний үнэ: 940,000,000.0 төгрөг/ тус тус байна.

Тус компани тендертээ барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 09/2022 дугаартай дүгнэлт, 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 39 дугаартай дүгнэлт, мөн Барилгын хөгжлийн төвийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 2/661 тоот тодорхойлолт тус тус ирүүлсэн байна.

Барилгын хөгжлийн төвийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 2/661 тоот тодорхойлолтод ““Өлке констракшн” ХХК нь “Цэцэрлэгийн барилга, 100 ор (Баян-Өлгий, Цэнгэл сум) төсөл арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 09/2022 комиссын дүгнэлтээр, “Сургуулийн дотуур байрны шинэчлэл, тохижилт (Увс, Ховд сум)” төсөл арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 40 дугаартай комиссын дүгнэлтээр тус тус ашиглалтад оруулсан” гэж дурдсан байх тул тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан шаардлагын дагуу оролцогч гэрээ дүгнэсэн акт, захиалагчийн тодорхойлолтын аль нэгийг ирүүлэх утгатай байгааг дурдах нь зүйтэй байна.

3.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2.3-т “Ажил гүйцэтгэх хугацааны нарийвчилсан хуваарь гарган баталгаажуулж ирүүлнэ. /Хуанлийн 75 хоног.” гэж заасан байна.

“Өлке констракшн” ХХК тендерт Баян-Өлгий аймаг-Цэнгэл тооцооны төвийн барилга угсралтын ажлын график нэртэй нийт 71 хоног гүйцэтгэх хуваарь бүхий 19

үе шатны ажилбартай ажил гүйцэтгэх хугацааны нарийвчилсан хуваарь ирүүлснийг шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

4.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д "Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана. Үүнд: 5 тн-оос дээш авто кран /5 тн нь тооцогдоно/. Тоног төхөөрөмж, техник хэрэгслийг түрээсээр ашиглаж болно. Техник хэрэгслийн мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан хянан үзэх тул "улсын дугаар"-ын мэдээллийг ирүүлнэ. Хэрэв түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээний хуулбарыг ирүүлнэ." гэж заасан байна.

Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.5-д заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс захиалагч "Еба констракшн" ХХК-ийн тоног төхөөрөмжийн мэдээллийг шалгахад тус компанийн тендерт санал болгосон 8251УНУ улсын дугаартай авто краны бүх жин 27000 кг, даац 0 кг байхад шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн нь үндэслэлгүй байна.

Тендерийн шалгаруулалтын хувийг хэрэгт "Еба констракшн" ХХК-ийн санал болгосон 8251УНУ улсын дугаартай авто краны даац 0 кг байгаа асуудлыг тодорхойгүй, эсхүл зөрчилдөөнтэй гэж үзэж тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 27.1-д зааснаар тодруулсан талаарх баримт бичиг, мэдээлэл байхгүй байгааг дурдах нь зүйтэй байна.


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 17/3133 тоот гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Еба констракшн" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ